

ЗДТГ-ын даргын 1021 оны 02 сарын 15-ний
өдрийн 1/02 дугаар тушаалын хавсралт

ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмын зорилго нь төрийн албан хаагчийн баримтлах ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2 Ёс зүйн зөвлөл нь Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, , Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль болон энэхүү журмыг баримтална.

Хоёр. Ёс зүйн зөвлөл

2.1 Ёс зүйн зөвлөл ЗДТГ-ын даргын шийдвэрээр 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, ёс зүйн хорооны даргыг томилно.

2.2 Ёс зүйн зөвлөл нь төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг хүлээн авч, түүний үндэслэлийг шалган тогтоож, дүгнэлт гаргана.

2.3 Ёс зүйн зөвлөл нь хэлтсийн нийт ажилтнуудын саналаар сонгогдсон, ажилтнуудын ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг хүлээн авч, түүний үндэслэлийг шалган тогтоож, дүгнэлт гаргах эрх, чиг үүрэг бүхий байнгын ажиллагаатай орон тооны бус байна.

2.4 Ёс зүйн зөвлөл нь үйл ажиллагаандаа тэгш хандах, шударга ёсыг баримтлах, нууцийг хадгалах, хараат бус байх зарчмуудыг баримтална.

2.5 Ёс зүйн зөвлөлийн шийдвэрийг байгууллагын ажилтнууд дагаж мөрдөнө.

2.6 Ёс зүйн зөвлөл нь дараах эрх, үүрэгтэй ажиллана. Үүнд:

2.6.1 Төрийн захиргааны албан хаагчийн баримтлах ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах

2.6.2 Гомдол, мэдээлэлд холбогдох төрийн захиргааны албан хаагч болон түүний харьяалах төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан, гомдол, мэдээлэл гаргагчтай уулзаж, тэдний тайлбар, саналыг сонсох, холбогдох нотолгоо, материал, баримт бичгийг шаардан авах

2.6.3 Гомдол, мэдээллийн нууцлалыг хадгалах, шаардлагатай гэж үзвэл, гомдол, мэдээлэл гаргагчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авахуулахаар холбогдох байгууллагад хандах

2.6.4 Гомдол, мэдээллийг шалгасан тухай дүнг хуралдаанаараа хэлэлцэж, гишүүдийн олонхийн саналаар дүгнэлт гаргах

2.6.5 Гомдол, мэдээллээс гадна хэвлэл, мэдээллийн хэрэгслийн мэдээллийн мөрөөр, түүнчлэн өөрийн санаачлагаар болон байгууллагын удирдлагын шийдвэрээр ёс зүйн зөрчлийг шалган тогтоож, дүгнэлт гаргах

Гурав. Ёс зүйн зөвлөлийн дүгнэлт

3.1 Ёс зүйн зөвлөл дүгнэлтээ Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 129 дүгээр тогтоолын 2.2-т заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтанд (даргад) танилцуулна.

3.2 Эрх бүхий байгууллага, албан тушаалтан /дарга/ нь Ёс зүйн зөвлөлийн дүгнэлтийг хянаж үзээд, дараах үндэслэлээр дахин шалгуулахаар Ёс зүйн зөвлөлд буцаах шийдвэр гаргаж болно. Үүнд:

- Ёс зүйн зөрчил гаргасны нотолгоо, баримт бичгийн бүрдэл хангагдаагүй
- Холбогдох нотолгоо, баримт бичиг, материалыг шалгаагүй буюу хангалтгүй шалгасан.